

“МОНОС ХҮНС” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Огноо: 2021-03-31

Хурал хийсэн газар: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороо, Монос хүнс ХК-ийн шингэн хүнсний үйлдвэрийн байрнаас шууд дамжуулалтаар <https://meeting.monosfood.mn/shareholder/login/5/> вэб хуудсаар болон Монос хүнс ХК-ийн <https://www.facebook.com/MonosFoods> фэйсбүүк групп, <https://www.facebook.com/groups/1030367210486131> Монос хүнс ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн фэйсбүүк группээр шууд цацагдаж, цахимаар хуралдав.

Эхэлсэн цаг: 15:00

Дууссан цаг: 17:00

Хурлыг зарласан: Монос Хүнс ХК

Хурлын зохион байгуулагч бүрэлдэхүүн:

Хурлын дарга: ТУЗ-ийн гишүүн Х.Ананд

Хурал зохион байгуулах комиссын дарга: Үйл ажиллагаа хариуцсан захирал П.Тодрол

Тооллогын комиссын дарга: Санхүүгийн менежер Э.Амарболд

Тооллогын комиссын гишүүд: Санхүүгийн шинжээч М.Энхбаяр

Бизнес аналит Ц.Дөлгөөнмайдар

Тэмдэглэл хөтлөсөн: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Н.Цагаанхүү

Хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2020 оны санхүүгийн тайланд аудит хийсэн хөндлөнгийн компанийн аудитын дүгнэлтийг танилцуулах,
2. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах,
3. Ногдол ашиг хуваарилах тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаас гарсан тогтоолыг танилцуулах,
4. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2021 оны төсвийг батлах,

Хурлыг компанийн Гүйцэтгэх захирал А.Отгондарь нээж, 2021 оны 2 сарын 18 өдрийн 35/02 тоот ТУЗ тогтоолоор хурлын даргаар томилогдсон Б.Гантулга тодорхой шалтгааны улмаас хурлыг даргалах боломжгүй гэсэн хүсэлт ирүүлсний дагуу КТХ-ийн 60.5-д заасныг үндэслэн 2021 оны 03 сарын 25 өдрийн 02/03 тоот ТУЗ тогтоолоор ХЭЭХ-ын даргаар ТУЗ гишүүн, СБХХ-ы дарга Х.Анандыг томилсон тогтоолыг танилцуулав.

Монос Хүнс ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дарга, ТУЗ-ийн гишүүн Х.Ананд хуралд оролцож байгаа бүрэлдэхүүнийг танилцуулав.

Хуралд ТУЗ-ийн гишүүн, СБХХ-ны дарга Х.Ананд,

ТУЗ-ийн хараат бус гишүүн, СБХХ болон НДЦУХ-ны гишүүн Ч.Чинзориг,

ТУЗ-ийн гишүүн, АХ-ны гишүүн Ц.Цэцэгбадам,

ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал А.Отгондарь,

БДО Аудит ХХК-ийн Гүйцэтгэх захирал Д.Алтансүх,

Ахлах аудитор Б.Бямбасүрэн нар оролцов.

Мөн хурлын дэгийг танилцуулав. Дэгийн дагуу:

1. Монос хүнс ХК-ийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах Гүйцэтгэх захирал А.Отгондарь
2. Монос хүнс ХК-ийн 2020 оны аудитлагдсан санхүүгийн тайланг танилцуулах, тайланг ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны гишүүн Ц.Цэцэгбадам,
3. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-ийн өгсөн дүгнэлтийг танилцуулах, дүгнэлтийг ТУЗ-ийн СБХХ-ы дарга Х.Ананд,
4. Ногдол ашиг тараах тогтоол, ТУЗ-ийн хараат бус гишүүн Ч.Чинзориг
5. ТУЗ-ийн 2021 оны төсвийн саналыг танилцуулах, ТУЗ-ийн гишүүн, АХ-ны гишүүн Ц.Цэцэгбадам,
6. Хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн асуултанд хариулт өгөх ТУЗ төлөөлөл, Гүйцэтгэх захирал
7. Санал хураалтын дүнг танилцуулах, Тооллогын комиссын дарга Э.Амарболд,
8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоолыг танилцуулах, хурлыг хаах, Хурлын дарга Х.Ананд

ТУЗ-ийн 35/02 дугаартай “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай” тогтоолоор томилогдсон тооллогын комиссын бүрэлдэхүүнийг уншиж танилцуулан Тооллогын комиссын дарга Э.Амарболдыг индэрт урив.

Тооллогын комиссын дарга Э.Амарболд: Нийт хувьцаа эзэмшигчиддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирцийг баталгаажуулах Тооллогын комиссын тогтоолыг уншиж танилцуулъя. Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.1, 67.3.2, 67.3.8, 68.4 дахь хэсгийг тус тус үндэслэн Компанийн саналын эрх бүхий энгийн нийт 408,850,428 ширхэг хувьцаанаас саналын эрхтэй 333,137,883 ширхэг хувьцаа буюу 81,48%-ийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид энэ хуралд цахим ханалт хийн оролцож байгаа тул хурлыг хүчин төгөлдөрт тооцож байна. Тооллогын комисс

Хурлын дарга Х.Ананд: Тооллогын комиссын тогтоолтой танилцлаа. Нийт хувьцаа эзэмшигчид та бүхэн системээс таны мэйл хаягаар илгээсэн нэвтрэх нэр, нууц үгээрээ вэб хуудаст нэвтрэн хуралдаа идэвхтэй оролцож, асуултаа асууж, саналаа өгөөрэй. Дэгийн дагуу Гүйцэтгэх захирал А.Отгондарь компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг, ТУЗ-ийн гишүүн, АХ-ы гишүүн Ц.Цэцэгбадам компанийн аудитлагдсан тайланг танилцуулна.

Гүйцэтгэх захирал А.Отгондарь тайланг танилцуулав. Тайланг тэмдэглэлд хавсаргав.

Хурлын дарга Х.Ананд: Дэгийн дагуу ТУЗ-ийн гишүүн, АХ-ы гишүүн Ц.Цэцэгбадам компанийн аудитлагдсан тайланг танилцуулна.

Хэлэлцэх асуудал 1: “Монос Хүнс” ХК-ийн 2020 оны санхүүгийн тайланг болон хөндлөнгийн аудитын компани БДО аудит ХХК-аас гаргасан дүгнэлтийг танилцуулав. Тайланг тэмдэглэлд хавсаргав.

Хурлын дарга Х.Ананд: 2020 оны санхүү, үйл ажиллагааны тайланг танилцуулсан Гүйцэтгэх захирал А.Отгондарь, мөн аудитлагдсан тайланг танилцуулсан ТУЗ гишүүн Ц.Цэцэгбадам нартаа баярлалаа.

Хэлэлцэх асуудал 2: Хурлын дэгийн дагуу хэлэлцэх асуудлын 3-т заасан “Монос Хүнс” ХК-ийн ТУЗ-ийн танилцуулга, хурлын явц, компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг хурлын дарга миний бие уншиж танилцуулъя. Дүгнэлтийг тэмдэглэлд хавсаргав.

Хэлэлцэх асуудал 3: Хурлын дэгийн дагуу ТУЗ-ийн хараат бус гишүүн, СБХХ-ы болон НДЦУХ-ы гишүүн Ч.Чинзориг 2021 оны 02 дугаар сарын 18 өдрийн 34/02 тоот “Ногдол ашиг хуваарилах тухай”

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоолыг эх хувиар нь уншиж танилцуулав. Тогтоолыг тэмдэглэлд хавсаргав.

Хэлэлцэх асуудал 4: Хурлын дэгийн дагуу ТУЗ-ийн гишүүн, АХ-ы гишүүн Ц.Цэцэгбадам ТУЗ-ийн 2021 оны зардлын төсвийг танилцуулав. Төсөвийн задаргаа танилцуулгыг хавсаргав.

Асуулт хариулт: Цахим хурлыг дамжуулж байгаа вэб хуудаст байрласан Санал асуулт талбараар орж асуултаа бичин илгээх товч дарж хариултыг асах талаар Хурлын дарга Х.Ананд дахин тайлбар хийв. Хэлэлцэж байгаа асуудлуудтай холбоотой асуултаа асуух боломжийг олгон 10 минутын хугацаанд хувьцаа эзэмшигчдэд асуултаа илгээх боломж олгохоор түр засварлая.

Хурлын дарга Х.Ананд: Хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн асуултанд хариулья. Асуултууд давхардсан байгаа тул асуултуудаа уншаад хариултаа аваад явья.

Асуулт №01: Э.Энхтүвшин: Ковидын үед ажилтангаа хэрхэн хамгаалж байна вэ? ямар арга хэмжээнүүд авч байна? Шинээр гарах бүтээгдэхүүний талаар мэдээлэл өгөөч хэзээ худалдаанд гарах бэ?

Асуулт №02: Б.Саранчимэг: Хатуу хөл хорионы үед ямар зохицуулалттай ажиллаж байгаа вэ?

Асуулт №03: А.Одонгэрэл: Үйлдвэр бүрэн ашиглалтанд орсон уу? Ороогүй бол яагаад? Хэзээ ашиглалтанд орох уу?

Асуулт №04: М.Тэмүүжин: 2021 оны борлуулалт хэд байхаар төлөвлөж байна. Ковидын нөлөө байгаа юу?

Хариулт: Гүйцэтгэх захирал А.Отгондарь:

1. Ковидын нөхцөл байдал нь амаргүй сорилыг давах байдлыг бизнес эрхлэгчдэд үүсгэж байгаа. Хамгийн үнэт зүйл болсон ажилтнуудаа хамгаалах талаар ажил олгогчоос эрсдлийн төлөвлөгөөний дагуу хийж байна. Үүнд: “Мандал даатгал”-д бүх ажилтнуудаа “Ковидын эрсдлийн даатгал”-д даатгуулсан. Ажлын байранд ариутгал халдваргүйжүүлэлтийг өндөр түвшинд хийж эрсдлээс хамгаалж ажиллаж байна. Үүнтэй холбоотой компанийн ариутгал халдваргүйжүүлэлтэд зарцуулах зардал өнгөрсөн онтой харьцуулахад 4-5 дахин өсөж 100 сая орчим төгрөгийг зарцуулж үйлдвэрлэлээ хэвийн явуулахад анхаарч ажиллаж байна. Мөн улсын хэмжээнд явагдаж байгаа вакцинжуулалтанд ажилтнуудаа хамруулж эхлээд байна. Манай компани хуурай хүнсний, шингэн хүнсний гэсэн 2 үйлдвэртэй бөгөөд үйлдвэрүүд өөр өөр дүүргүүдэд харьяалагддаг, Баянгол дүүрэгт байрлах шингэн хүнсний үйлдвэрийн ажилтнууд эхний тунгаа хийлгэсэн дараа 7 хоногоос 2 дахь тунгаа хийлгэх хуваарьтай байна. Хан-уул дүүрэгт байрлах хуурай хүнсний үйлдвэрийн ажилтнууд өнөөдөр хамрагдаж байна.
2. Хатуу хөл хорионы үед зайнаас ажиллах боломжтой ажилтнуудыг зайнаас ажиллуулж, бусад зайлшгүй ажиллах ажилтнуудыг дэглэмийг сайтар хангуулан ажиллаж байна. Шөнийн түгээлт зэрэг гэнэтийн гэнэтийн сорилууд үйлдвэрлэгч бидэнд тулгарч тэр бүрт эрсдэлийн төлөвлөгөөнд заасны дагуу ажлаа зохион байгуулж ажиллаж байна.
3. Шинээр гаргах бүтээгдэхүүний тухайд шингэн хүнсний үйлдвэрийн халуун савалгааны төхөөрөмж бүрэн ашиглалтанд ороогүй учир ашиглаж эхэлснээр төлөвлөж байгаа зарим шинээр хөгжүүлэх бүтээгдэхүүнээ хийэ зах зээлд гаргана. Тухайлбал: “ ашиглаж эхэлснээр төлөвлөж байгаа зарим шинээр хөгжүүлэх бүтээгдэхүүнээ хийэ зах зээлд гаргана. Тухайлбал: “ice tea”, витамин С-ын өндөр агууламжтай “Вита С” зэрэг бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхээр төлөвлөж байна.
4. Үйлдвэр ашиглалтанд ороогүй шалтгааныг тайлан дээрээ бас дурдсан. Ковид цар тахлаас шалтгаалан шинээр ашиглалтанд орж байгаа үйлдвэрийн халуун савалгаа зэрэг зарим шугам ашиглалтанд ороогүй, тоног төхөөрөмжийг угсран хүлээлцэх инженерүүд хил хаагдсантай холбоотой ирж хүлээлцэж чадахгүй, 2 шугам ашиглалтанд ороогүй байгаа зэрэг нь нөлөөлж байна. Бид хугацаа

алдахгүй байх үүднээс зайнаас зөвлөгөө аван инженер техникийн албаны ажитнуудын хүчээр тоног төхөөрөмж угсралтын тест сайжруулалтыг тасралтгүй хийсээр байна.

5. 2021 оны борлуулалтын төлөвлөгөөг 16.6 тэрбум гэж төлөвлөж байна. Мэдээж хүнд сорил ихтэй энэ үед 33%-ийн өсөлттэйгээр төлөвлөнө гэдэг амаргүй. Гэхдээ манай бүтээгдэхүүн эрүүл мэндийг дэмжих, дархлаа дэмжих онцлогтой учир энэ цаг үед борлуулалт нэмэгдсэн учир би маркетинг идэвхжүүлэлтэндээ анхаарч энэ төлөвлөгөөндөө хүрэхээр зорин ажиллах болно.

Хурлын дарга Х.Ананд: Дахин 7 асуулт ирүүлсэн байна.

Асуулт №05: Б.Батбаатар: Хувьцаа ерөн л ямар ч өөрчлөлтгүй 3 жил боллоо юундаа байна вэ? Бусад компаниудын хувьцаа өсөлт дэвшилттэй харагдаж байна.

Асуулт №06: П.Уранчимэг: Өтгөрүүлсэн барагшун их таалагдсан. Тайлбар ном нь ойлгомжтой хэрэгтэй бүтээгдэхүүн болсон байна. Хар саримс бүтээгдэхүүн чинь хаанаас оруулаж ирдэг вэ. угаасаа хар ургасан саримс юм уу?

Асуулт №07: Л.Алтанцогт: Шингэн хүнсний үйлдвэр 100% хүчин чадлаараа ажиллаж байгаа юу?

Асуулт №08: Д.Мөнхтуул: 2019 оны ашгаа авч чадаагүй энэ жил нөхөөд авч болохуу?

Асуулт №09: П.Уранчимэг: Экос усны дараагийн төрөл юутай байх вэ? цайрын агууламжтай ус гаргах уу?

Асуулт №10: Т.Буянхишиг: ТУЗ-ийн 2021 оны төсвийн саналыг дэлгэрэнгүй тайлбарлаж өгнө үү?

Хариулт: Гүйцэтгэх захирал А.Отгондарь:

- Бид 2019 оны 5 сард анхдагч зах зээлд хувьцаагаа анх арилжаалсан. Хувьцаат компани болсноос хойш 1,5 жил болсны үр дүнг өнөөдөр танилцуулж байна. Хувьцааны ханшийн өсөлтөд Ковидын үеийн зах зээл бас их нөлөөлж байна гэж бид дүгнэж байна. 2019 оны эхний хагас жил болон 2020 оны эхний хагас жилийн хөрөнгийн бирж дээрх хувьцааны ханшийн өөрчлөлтийг харахад ТОП 20 компанийн хувьцааны үнэ буурсан харагдаж байгаа. Өнөөдөр 72.3 гэсэн ханштай байна. 2020 оны хамгийн өндөр ханш 79 төгрөг хүрсэн. 2020 оны 1 дүгээр улиралд 106 сая төгрөгийн хувьцааны арилжаа хийгдэж байсан бол энэ оны 1 дүгээр улиралд 554 сая төгрөгийн арилжаа хийгдэж хувьцааны арилжаа идэвхтэй байгаа ч ханш өсөхгүй байгаа нь энэ цаг үеийн зах зээлийн онцлогоос шалтгаалж байгаа гэж харж байна. Бид ч хувьцааны ханшаа нэмэх талаар тодорхой ажлуудыг тогтмол хийж байна.
- Бид бүтээгдэхүүнээ сайжруулах үүднээс байнга ажиллаж байгаа тиймээс бүтээгдэхүүний тайлбарыг ном хэлбэрээр хүргэхээр зорьж байна.
- Шингэн хүнсний үйлдвэр бүрэн хүчин чадлаар ажиллахгүй байна. Шинэ үйлдвэр 4 савалгааны шугамтай хүйтэн савалгааны 2 шугам бүрэн ажиллаж байна, халуун савалгааны 2 шугам ашиглалтанд ороогүй үйлдвэр 75% хүчин чадлаар ажиллаж байна. Энэ ондоо ашиглалтанд оруулахаар зорьж байна.
- Хар саримс гэдэг нь энгийн саримсыг боловсруулалтанд оруулж байж гаргаж авдаг бөгөөд хар саримсанд байдаг агууламж нь энгийн саримсаас 10 дахин их өндөр агууламжтай байдаг учир хар саримсыг хэрэглэснээр энгийн саримсаас авдаг ач тустай зүйлийг 10 дахин өсгөн авах боломжтой юм. Мөн саримсын үнэр амтыг мэдрэх дургүй хүмүүс хар саримсыг хэрэглэхэд элдэв таагүй үнэр амт нь байхгүй учир хэрэглэх дуртай байдаг.
- ҮЦТХТ руу бид бүх хувьцаа эзэмшигчдийн ногдол ашгийг бөөнд нь шилжүүлдэг учир авч болно. Ойрын хугацаанд компанийн вэб сайтад ногдол ашгийг ямар шат дарааллын дагуу авдаг талаар мэдээллийг оруулж тавья. Та бүхэн хувьцааны дансаа нээлгэсэн брокерын компанид хандан ногдол ашгаа аваарай. Таны дансанд байршсан байгаа шүү.

6. Экос усны дараагийн төрөлд спорт усыг гаргахаар төлөвлөж байгаа бөгөөд хөлсөөр алдсан эрдсээ нөхөх агууламжтай ус юм. Цайрын агууламжтай усыг гаргахаар төлөвлөж байгаа.

Хариулт: ТУЗ гишүүн Ц.Цэцэгбадам:

7. ТУЗ-ийн 2021 оны төсвийн талаар нэмэлт тайлбар өгье.

ТУЗ-ийн хурлын зардалд 10 сая төгрөг төсөвлөсөн бөгөөд энэ нь өмнөх оноос өссөн байгаа, шалтгаан нь ээлжит бус хурлын зардлыг нэмж төсөвлөсөн юм. Өмнөх онд энэ зардлыг төлөвлөөгүй байсан. ХЭЭХ-ыг ирэх онд 25 сая төгрөгөөр төсөвлөсөн байгаа, шалтгаан нь цахимаар хурал хийх нь техник тоног төхөөрөмж, программ хөгжүүлэлт зэрэг төлөвлөгдөөгүй зардал их гарч байгаатай холбоотой нэмэгдсэн. ТУЗ цалин төсөвд ээлжит бус хурлын зардлыг нэмж тооцоолсноос өссөн. 2020 онд 49 сая төгрөг төсөвлөж байсан бол 2021 онд 78 сая төгрөгийн зардлыг тооцоолон төлөвлөөд байна.

Асуулт №11: Лувсандорж: Экспорт төлөвлөж байгаа юу?

Асуулт №12: М.Бямбасүрэн: Цар тахлын үед ногдол ашиг тарааж байгаа шалтгаан нь юу вэ?

Асуулт №13: XXX ALADARITU: Түүхий эд сав баглаа зэргийг 2-3 сараар нөөцөлнө гэж байна. Эргэлтийн хөрөнгө хангалттай байгаа юу? Хэрвээ борлуулалт буурч мөнгөний эргэлт хангалтгүй бол ямар гарцаар шийдэх бэ?

Асуулт №14: Мөнгөнтүүл: Хувьцааны дансаа яаж мэдэх бэ?

Хариулт: Гүйцэтгэх захирал А.Отгондарь:

1. Экспортын хувьд бид нилээн зорьж ажиллаж байна. Компанийн хувьд “Монгол оюун санааг дэлхийд таниулна” гэсэн алсын хараатайгаар Монгол эрдэмтдийн бүтээл бүтээгдэхүүнийг дэлхийд таниулахаар зорин ажилладаг. Бид онлайн зах зээлд ажиллахаар Амазон зэрэг онлайн дэлгүүр бусад сүлжээ онлайн худалдааны шугамуудыг их судлан хамтран ажиллаж байна. Экспортод гарахын тулд чанарын стандартыг сайн хангасан байх шаардлага үүсдэг бөгөөд компани олон улсад зөвшөөрөгдсөн олон стандартыг хэрэгжүүлэхээр ажиллаж байгаа нь бидний ажлыг хөнгөвчилж, дэмжлэг болж байна.
2. Компани маань хувьцаат компани болохдоо нийт хувьцаа эзэмшигчдээ жил бүр ашгийн 30%-с доошгүйг ногдол ашиг хэлбэрээр тарааж байхаар амласан, амлалтын дагуу нөхцөл байдал хүнд байгаа хэдий ч ТУЗ бүрэлдэхүүнээр хэлэлцээд компани ашигтай ажилласан учир ногдол ашиг тараах шийдвэр гаргасан. Энэ нь хувьцааны үнэ ханшид эерэгээр нөлөөлөх, хувьцаа эзэмшигчид компанидаа итгэлтэй байхад нөлөөлнө гэж бид үзэж байгаа юм.
3. Сав баглаа боодлыг 2-3 сар нөөцлөх нь ажлын капитал талаасаа биднийг мөнгөний их нөөцтэй байх шаардлагыг үүсгэж байгаа ч мөнгөн урсгалын менежмент, авлага менежментээ зохицуулаад аль болох өөрсдийн чөлөөт мөнгөн урсгалаар асуудлаа шийдвэрлээд явна.

Хурлын дарга Х.Ананд: Хурлын дэгд заасны дагуу асуулт хариултын цаг дуусч байна. Та бүхэн асуух зүйлээ асуулт талбарт үлдээгээрэй. Бид таны мэйлээр хариултыг илгээх болно. Дэг ёсоор одоо 16 цаг 10 минут болж байна, санал хураалтын цаг эхэллээ. 10 минутын хугацаанд хувьцаа эзэмшигч та бүхэн саналаа өгөөрэй. /Цаг тоолж эхлэв/

Хурлын дарга Х.Ананд: Ийнхүү Монос хүнс ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцогчдын саналын хүлээн авах хугацаа дууслаа. Саналаа өгч хуралдаа идэвхтэй оролцсон нийт хувьцаа эзэмшигч та бүхэнд баярлалаа. Одоо Тооллогын комисс хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн саналыг нэгтгэх ажлаа эхлүүлж байна.

Санал хураалт 16 цаг 45 минутад өндөрлөж, саналын дүнг нэгтгэж эхлэв. Тооллогын комисс 16 цаг 55 минутанд санал хураалтын дүнг нэгтгэж дуусаад танилцуулав.

Хурлын дарга Х.Ананд: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал үргэлжилж байна. Тооллогын комиссын дарга Э.Амарболдыг санал хураалтын дүнгийн нэгтгэлийг танилцуулна уу гэж урья.

Тооллогын комиссын дарга Э.Амарболд: Санал хураалтын дүнг нэгтгэн танилцуулья. Тооллогын комиссын тогтоол №02 уншиж танилцуулав.

Хурлын дарга Х.Ананд санал асуулгын дүнд үндэслэн “Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай”, “Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны төсвийг батлах тухай” тогтоолуудыг нийт хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонх зөвшөөрсөн тул ХЭЭХ-ын тогтоолыг баталж, 17 цаг 00 минутанд уншиж танилцууллаа.

Хурлын дарга Х.Ананд: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд идэвхтэй оролцсон нийт хувьцаа эзэмшигч нартаа баярлалаа. Хурлын үйл ажиллагаа хаасныг мэдэгдье гэснээр хурал 17 цаг 05 минутанд дуусав.

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА *Н.Цагаанхүү* Н.ЦАГААНХҮҮ

ТЭМДЭГЛЭЛ ХЯНАСАН:

ХУРЛЫН ДАРГА..... *Х.Ананд* Х.АНАНД

